



Г

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

Г

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.11.25 № 03/2191
таний -ны № -т

Г Тодруулга хүргүүлэх тухай Г

Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1228 дугаар захирамжаар худалдан авах ажиллагааны эрх шилжин ирсэн БШУЯ/20240101099/01/01 дугаартай “Цэцэрлэгийн барилга, 100 ор (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 7 дугаар хороо)” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтад сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах хүсэлт ирүүлсний дагуу дараах хариу хүргүүлж байна. Үүнд:

№	Тодруулга	Тодруулгын хариу
1	<p>Тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1 дэх хэсгийн шаардгах ажиллах хүчиний мэдээлэлд Халаалт агаар сэлгэлтийн инженер-1, 3 болон түүнээс дээш жил ажилласан туршлагатай байх гэж шаардсан.</p> <p>Асуулт 1: Халаалт агаар сэлгэлтийн инженер шаардсаны дагуу манай компаниас Дэлгэрэхийн Хангайг санал болгож байгаа бөгөөд баклаврын диплом дээр "Хүрээлэн буй орчны инженер" гэсэн байгаа боловч хавсралт дүнгийн хуудсан дээрх мэргэжил хэсэгт "Халаалт, агаар сэлгэлт" гэсэн байгаа нь тендерийн өгөгдлийн хүснэгтэд шаардсан Халаалт агаар сэлгэлтийн инженерээр санал болгож болох уу? Хавсралтаар дипломын хуулбарыг хүргүүлэв.</p>	<p>Хариулт 1: ТШЗ 19.2. а) Тендерт оролцогчийн үндсэн ажилтан, хөлсөөр ажиллах гэрээний дагуу ажиллах ажилтны мэдээллийг цахим систем дэх V бүлэгт заасан маягт 2-аар зааварчилгааны дагуу санал болгоно. Цахим системээр санал болгоогүй тохиолдолд хянан үзэхгүй. Цахим системийн хэрэглэгчийн хөтөч цэсний нийлүүлэгчийн гарын авлага хэсгээс зааварчилгаатай танилцана уу.</p> <p>б) Ажилтны сургууль төгссөн дипломын хуулбарыг ирүүлэх шаардлагагүй, төрийн мэдээлэл, солилцооны ХҮР системээр дамжуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллийн сангаас шалгана. (Тендерт оролцогч нь Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia)-д ажилтны дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг урьдчилан шалгах шаардлагатай анхаарна уу.)</p> <p>Монгол улсын Боловсрол, Шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/146 дугаар тушаалаар батлагдсан Мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекс шинэчлэн батлах тухай тушаалын нэгдүгээр хавсралтад заасан Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн</p>

		нэр/, индексийг үнэлгээнд харгалзан үзнэ.
2	Асуулт 2: Түрээсээр гэрээ хийх ИТА болон машин механизмыг өөр гүйцэтгэлийн хувь нь 70%-даа хүрээгүй байгаа тендерт давхцаж байгаа эсэхийг хаанаас шалгаж болох вэ?	<p>Хариулт 2:</p> <p>ТШЗ-19.2-д зааснаар (Дээрх машин механизмын эзэмшигчийн талаарх мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-ээр дамжуулан шалгана. Зөрсөн тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.)</p> <p>Захиалагч ажлын гүйцэтгэлийн явц, ажилтан, машин механизмын талаарх мэдээллийг холбогдох байгууллагын мэдээллийг сангаас хянан үзнэ.</p>
3	Асуулт 3: Зураг төсөл зохиох компани нь туслан гүйцэтгэгчээр тендерт орж байгаа бөгөөд татвар, нийгмийн даатгалын өртэй байж болох уу?	<p>Хариулт 3:</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу Оролцогчийн ерөнхий шаардлагыг магадална.</p> <p>Оролцогч гэдэг нь хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалтын дагуу тендер шалгаруулалтад дангаар эсхүл түншлэлээр тендер ирүүлсэн аж ахуй эрхлэгчийг хэлнэ.</p>

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт заасны дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.